

КОМПАНИЙН 2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

- 1. Компанийн бизнесийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл** Хөнгөн Бетон ХК нь түрээс болон дэд бүтцээ ашиглуулах үйл ажиллагаа явуулж байна. Энэхүү тогтмол орлогоороо өр төлбөрөө барагдуулах нь бэлэн мөнгө хомсдолтой үед их нэмэртэй байлаа.
- 2. Санхүүгийн байдлын талаарх мэдээлэл** Компани 2021 онд 1,306,331,000 төгрөгийн орлого олсон ба түрээсийн үйл ажиллагаа явуулж орлого олж байна. Шүүхийн шийдвэрийн өр төлбөрт тодорхой төлөлтүүд хийгдэн 8 хавтаст хэрэг байснаас 6 хавтаст хэргийг хаасан. Шүүхийн шийдвэртэй 2 хавтаст хэрэг нийт 59,4 сая төгрөгийг өглөгтэй байна. Авлага шүүхийн шатанд явж байгаа ба 150,0 сая төгрөг байна. Банкны өр төлбөр одоогоор оны эцсийн байдлаар 2,67 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

3. Хувьцаа эзэмшигчдийн талаарх мэдээлэл

“Хөнгөн бетон” ХК-ийн нийт гаргасан хувьцааны тоо 179,373 ширхэг. 2022 оны 3 дугаар сарын 11-ны өдрийн байдлаар Үнэт цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төвөөс ирүүлсэн 5 ба түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшигчдийн хувь эзэмшлийн судалгаагаар дараах байдлаар хувьцаа эзэмшиж байна.

Д/д	Хувьцаа эзэмшигчдийн нэрс	Тоо ширхэг	Хувь
1	Б.Наранзул	72,625	40,5%
	Б.Наранцацралт	88,577	49,4%
	“Минжит булган гол” ХХК	14,918	8,3%
	Т.Баярхүү /өв залгамжлагч Б.Наранзул, Б Наранцацралт/	1,034	0,6
		177,154	98,8%

4. Ногдол ашгийн талаарх мэдээлэл

- 1) “Хөнгөн бетон” ХК болон “Хас банк” ХХК-ийн хооронд 2012 оны 11-р сард байгуулагдсан “Хугацаат зээлийн гэрээ”-ний “Зээлдэгч нь аливаа ногдол ашиг зарлахгүй, олгохгүй” тухай “Хавсралт 3 В.1” дүгээр заалтыг үндэслэн ногдол ашиг олгохгүй байгаа.
- 2) “Хөнгөн бетон” ХК нь банкны өмнө хүлээсэн үүргийн дагуу ногдол ашиг хуваарилах боломжгүй.

ТУЗ-ИЙН ДАРГА   Б.НАРАНЗУЛ